



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/109

Алтай хот

Улсын хошой болон аварга малчид,  
аварга тариаланч, Алтан төлийн эздэд  
хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хошой болон аварга малчин, тариаланчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, Алтан төлийн эздийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар, хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шаардагдах 8,457,000 (найман сая дөрвөн зуун тавин долоон мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

